



УУЛ УУРХАЙН САЙД
Р.ЖИГЖИД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015.04.01 № 2/45

Асуудлыг шийдвэрлэх тухай

Газрын тосны газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2013-2014 оны хичээлийн жилд суралцагсдаас бакалавр 3, магистрын 8, нийт 11 суралцагч уул уурхайн болон газрын тосны мэргэжлийн чиглэлээс өөр мэргэжлээр суралцаж байгаа нь “Журам батлах тухай” ЗГ-ын 2013 оны 291 тогтоолоор баталсан журмын 2.2.1-д “бакалаврын сургалтад хамрагдах иргэн нь газрын тос, уул уурхайн чиглэлээр дотоодын их, дээд сургуулийн 2 дугаар курс, түүнээс дээш курсын оюутан гадаадын сургуульд мэргэжлээрээ шилжин суралцах эрх авсан 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй бол”; 2.2.3-т “магистрын сургалтад хамрагдах иргэн нь газрын тос, уул уурхайн салбарын чиглэлийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил багшилсан эсвэл ажилласан байх”; гэсэн заалтуудтай тус бүр нийцэхгүй байна.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвөөс 2013, 2014 оны тэтгэлэгт шалгалтад оролцогсдын нэгтгэсэн дүн, шалгалтын материалыг гаргуулан авсан ба дээрх материалуудыг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ.

- 2013 оны бакалаврын шалгалтад тэнцсэн суралцагсдын нэрсийн тулган баталгаажуулалтаар Боловсролын үнэлгээний төв /БҮТ/-өөс зохион байгуулсан шалгалтад ороогүй Д.Наранцогт нь УУЯ-ны ТНБД-ын тушаалаар ГТГ-ын тэтгэлгээр суралцаж байна;
- Мөн Боловсролын үнэлгээний төв /БҮТ/-ийн шалгалтын дүнгээр 36-аас дээш оноотой 5 шалгуулагч байхад 28-32.5 оноотой 3 шалгуулагчийг УУЯ-ны ТНБД-ын тушаалаар ГТГ-ын тэтгэлгээр суралцуулж байна.
- Боловсролын үнэлгээний төв /БҮТ/-өөс авсан шалгалтын дүнгээр 40 оноотой Э.Долгормааг УУЯ-ны ТНБД-ын тушаалаар 67 оноогоор тэнцсэнд тооцож ГТГ-ын тэтгэлгээр суралцуулж байгаа бол БҮТ-өөс авсан шалгалтын дүнгээр 49 оноотой Г.Халиун нь УУЯ-ны ТНБД-ын тушаалгүйгээр ГТГ-ын тэтгэлгээр тус бүр суралцаж байна.
- 2013 оны магистрын шалгалтын дүнг Боловсролын үнэлгээний төв /БҮТ/-өөс ирүүлээгүй бөгөөд 2014 онд магистрын шалгалтад 38 шалгуулагч орсноос 11 иргэн тэнцсэн ба 65-аас дээш оноо авсан 15 иргэн байгаа боловч 50 оноо авсан Э.Батгэрэлийг УУЯ-ны ТНБД-ын тушаалаар баталгаажуулан ГТГ-ын тэтгэлгээр суралцуулж байна.

ГТГ-ын тэтгэлгээр суралцах иргэдийн сонгон шалгаруулалтын босго оноог тухайн үеийн шалгалтын комисс тогтоодог ба 2013-2014 онд суралцаж буй нийт бакалаврын 30 оюутнаас 26-г нь хэлний бэлтгэлийн хамт 5 жил, магистрын 18 оюутнаас 17-г нь хэлний бэлтгэлийн хамт 3 жилээр тус тус сургаж байгаа ба гэрээнд үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай заалт байхгүй нь төгсч ирээд

ажиллах, гэрээ зөрчсөн тохиолдолд нөхөн төлбөрийг төлүүлэх нөхцөл, заалтгүйгээр тэтгэлгийг 100 хувь олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2-т “Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг бакалаврт 2 жил, магистрантад 2 жил, докторантад 3 жил, докторын дараах сургалтад хамрагдагчид 1 жил хүртэлх хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно” мөн ЗГ-ын 2013 оны 291 тогтоолоор баталсан журмын 2 дугаар зүйлийн 2.3-т “Энэ журмын 2.2-т заасан сургалтад хамрагдах иргэн нь гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах гадаад хэлний мэдлэгийг бүрэн эзэмшсэн байх”, 3.3.3.1 болон 3.3.4.2-т “суралцахаар сонгосон улс, орныхоо сургалтын стандартыг хангах хэмжээнд гадаад хэлийг эзэмшсэнийг нотлох баримт бичиг”-тэй байна гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн доорх Албан шаардлагыг өгч байна.

1. “Журам батлах тухай” ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан журмын 2.3, 3.3.3.1, 3.3.4.2 дахь заалтууд болон ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2-т “Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг бакалаврт 2 жил, магистрантад 2 жил, докторантад 3 жил, докторын дараах сургалтад хамрагдагчид 1 жил хүртэлх хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно” гэснийг баримтлан гэрээнд өөрчлөлт оруулах, 2013, 2014 онд олгосон хэлний бэлтгэлийн төлбөрийг нөхөн суутгахаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цаашид хэлний бэлтгэлийн тэтгэлэг олгохыг таслан зогсоох;
2. Элсэгчдийн авбал зохих босго онооны доод хэмжээг тогтоож, шалгуурт оруулан мэдээлж, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журамд нийцүүлэн үнэн зөв зохион байгуулах, шийдвэрлэх;
3. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2015 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Оюун нарт даалгаж байна.

АУДИТОР



П.ЧАНЦАЛДУЛАМ